

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 оны 05 дугаар сарын 26

Мөрөн сум

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Монгол улсын хууль					
1	42.1, 43.1, 47.1, 50.1, 50.4, 56.1, 56.2, 60.1, 78.1, 99, 109.5, 109.8, 120.3, 137.1, 139.2, 144.2,	Хөдөлмөрийн тухай хууль (2021 оны 07 дугаар сарын 02)	-Боловсон хүчний тушаал шийлвэрийг хуулийн дагуу гаргах. Үүнд ажилтан томилох, чөлөөлөх, ажилтанд чөлөө олгох тушаал шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргасан. -Албан хаагчдын ээлжийн амралтыг хуулийн дагуу эдлүүлсэн. -Албан хаагчдын илүү цаг, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл зэрэг нэмэгдлүүдийг хуулийн дагуу олгосон. -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах чиглэлээр 122 ажилтнаас 5 ажилтан буюу хуулийн дагуу нийт ажилтны 4%-иас багагүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.	100%	
2	13.4, 10.2, 15	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль (1997.11.13)	Ус, цаг агаарын аюултай нөхцөл ажиглагдсан үед цаг уурын 24 салбар, ус судлалын 13 салбараас Аюул мэдээ 216, Агаар мэдээ 182, нийт 398 мэдээ дамжуулсан. Ус, Цаг уур, байгаль орчны ажиглалтын мэдээ бүрэн дамжигдсан. Урьдчилсан мэдээ, аюулт үзэгдэл, гамшгийн тухай урьдчилан сэргийлэх мэдээг аймаг, сум орон нутгийн хэмжээнд мэдээллийн сувгуудаар хүргэсэн.	100%	
3	8.1.4, 8.1.5, 27.1	Агаарын тухай хууль 2012.05.12	2024 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг Мөрөн сумын 14 баг, 23 сумдын төвийн багт зохион байгуулж дүн мэдээг ЦУОШГ-т хүргүүлсэн бөгөөд envpol.gov.mne. gov.mn хаягаар мэдээллийн санд оруулсан.	100%	
4	16.5	Төсвийн тухай хууль 2011.12.23	Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллагчдын цалин хөлсийг хууль журмын дагуу олгосон. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнасан.	100%	

1	2	3	4	5	6
5	8.7	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2012.1.19	ХАСХОМ-ийг нэр бүхий 5 албан хаагч хуульд заагдсан хугацаанд нь гарган баталгаажуулж, удирдах дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа.	100%	
6	5,6-р зүйл	Шилэн дансны тухай хууль	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр https://shilendans.gov.mn/ сайтад шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан.	100%	
7	60.1.1, 66.1,	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Хуурайшлын зэргийн мэдээг хавар 3-р сарын 20-ноос эхлэн 23 сум, 1 тосгоноор 66 удаа тооцоолон гаргаж, байгууллагын цахим хаяг, олон нийтийн сүлжээгээр иргэд, олон нийтэд хүргэв. Хуурайшилтын зэрэг аюултай болон нэн аюултай түвшинд хүрсэн үед Анхааруулах мэдээ бэлтгэн хүргэдэг. Аймгийн нутгаар хагас хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг өглөө бүр 08 цагт, 1-5 хоногийн урьдчилсан мэдээг өдөр бүр 15 цагт, 7 хоногийн цаг агаарын төлөв мэдээг Даваа гариг бүр гарган, олон нийтэд хүргэдэг. Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлж хуурайшлын зэрэг өндөр гарсан сумдад хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн	100%	
	17.2.16-17.2.21	Ойн тухай хууль			
8	10, 11, 13-р зүйл	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 2 удаагийн сургалт явуулж байгууллагын цахим хуудсанд сургалт сурталчилгааны мэдээлэл 3 удаа оруулсан	100%	
Засгийн газрын тогтоол					
1		Монгол улсын засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 139 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд.	“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үзэл санаа, зорилго, зорилт, үйл ажиллагаа, хүрэхээр зорьж буй үр дүн, Засгийн газраас гарч буй бодлого шийдвэрийн уялдаа холбооны талаарх цахим, танхим хосолсон сургалтанд сууж мэдлэг эзэмшиж, байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөгөөг энэхүү бодлоготой нийцүүлж, хэрэгжүүлж ажиллаж байна	100%	

1	2	3	4	5	6
2		-Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах” тухай журам, Засгийн газрын 260 дугаар тогтоол “Монгол Улсын дипломат, албан паспорт олгох, эзэмших, хадгалах журам”, Засгийн газрын 57 дугаар тогтоол “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг хэрэгжилтийг хангах	-БНСУ-ын Байгаль орчны яамны буцалтгүй 100%-ийн тусламжтай хэрэгжүүлж буй агаарын чанарын автомат станц суурилуулах ажлыг Мөрөн суманд хамтран зохион байгуулсан. - БНСУ-ын КОМПСАТ хиймэл дагуулын дүрс мэдээний заслага баталгаажилтын хэмжилтийн тэмдэгт, талбайн судалгааны ажилд 2019 оноос эхлэн оролцож байна.	100%	
3		Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"	Байгууллагын 42 албан хаагчид Монгол бичгийн 50 цагийн танхимын сургалт, 80 албан хаагчид Монгол бичгийн 50 цагийн цахим сургалт зохион байгуулсан. Үндэсний бичгийн “Хүмүн бичиг” сонины улирал бүрийн дугаарыг байгууллага хамт олноороо захиалан уншиж хэвшүүлсэн.	100%	
Биелэлтийн дундаж хувь				100%	

ТАЙЛАН БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН А.БЯМБАДОРЖ